

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Д. Ишдорж	Дугаар	L331
Оршин суугаа аймаг	Өвөрхангай	Оршин суугаа сум	Төгрөг сум
Төрсөн газар	Төгрөг сум	Төрсөн он	1922
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Уушигийн жас, Баянгийн жас	Сүм хийдийн дугаар	ӨХТГ 056, ӨХТГ 057
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 17	Ярилцлага авсан хүн	Жужа



Өвөрхангай аймгийн Төгрөг сумын Уушигийн жас, Баянгийн жасын тухай

Жужа: Уушигийн жас хэдэн дугантай байсан бэ?

Д. Ишдорж: Ганцхан гэр дуган байсан.

Жужа: Хашаатай байсан уу?

Д. Ишдорж: Хашаатай байсан. Модон хашаатай.

Жужа: Хэдэн лам сууж байсан?

Д. Ишдорж: Мэдэхгүй ээ, цөөхөн лам байсан. Ном үзэж байгаа хүүхдүүд нь орж байгаа юм.

Жужа: Хамба лам нь хэн байсан бэ?

Д. Ишдорж: Чойжоо гавж гэж хүн байсан. Ловон лам нь Самдан гэлэн гэж хүн байсан.

Энхбаяр: Тэр Самдан гэлэн ловон хүн байсан уу?

Д. Ишдорж: Ловон гэдэг чинь толгойлогч лам байдаг юм ш дээ. Хурал хураад суухад түшлэгтэй энэ тэр суудал дээр суудаг.

Жужа: Гол шүтээн нь ямар сахиус байсан бэ?

Д. Ишдорж: Дарь эх байсан . Цагаан, ногоон чинь өнгөний ялгаатай.

Жужа: Хийдийн сахиус ямар сахиус байсан бэ?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

- Д. Ишдорж: За ямар байсныг нь мэдэхгүй байна аа, мартчихаж.
- Жужа: Жасын гэр яг ийм гэр байсан уу?
- Д. Ишдорж: Том, гэр дуган. Модоор хийсэн.Хойноо тасалгаатай, бурхан тахил нь тэр хойд ардаа байдаг. Дотроо хурал хурдаг лам нарын суудалтай.
- Жужа: Суварга байсан уу?
- Д. Ишдорж: Суварга байсан. Нэг л суварга гадаа байдаг байсан.
- Энхбаяр: Тэр суварга аль талд нь байсан?
- Д. Ишдорж: Баруун хойд талд нь байсан.
- Жужа: Цагийн хурлууд ямар ямар хурал хурдаг байсан бэ?
- Д. Ишдорж: Гол хурал нь дарь эх хурдаг байсан. Дарь эхийн хурал дээр энэ тэндээс өвдсөн, зовсон улсууд маш их ирдэг байсан. За байз, өшөө чинь 29-ний гүйжир хурдаг байсан.
- Жужа: Шинийн найманд манал хурдаг байсан уу?
- Д. Ишдорж: Шинийн найманд манал үгүй байх аа. Тийм юм хурж байгаагүй.
- Жужа: Майдар эргэдэг байсан уу?
- Д. Ишдорж: Майдар эргэдэггүй байсан.
- Жужа: Ганжуур эргэдэг байсан уу?
- Д. Ишдорж: Үгүй ээ.Жижигхэн сүм чинь тэгж их олон ном хураад байдаггүй байсан.
- Жужа: Гавж цолтой хүн байсан уу?
- Д. Ишдорж: Чойдог гавж гэж нэг хүн байсан.
- Жужа: Гэлэн хүн байсан уу?
- Д. Ишдорж: Ганц нэг гэлэн хүн байсан.
- Жужа: Хайлан хурдаг байсан уу?
- Д. Ишдорж: Үгүй ээ.
- Жужа: Сожин сахидаг байсан уу?
- Д. Ишдорж: Үгүй ээ.
- Жужа: Лүйжин тавьдаг лам байсан уу?
- Д. Ишдорж: Байсан. Тийм зоч лам, цагаан булаг дээр л дуусдаг байсан даа. Зургаан булаг хэсдэг, тийм байсан юм.
- Жужа: Хэдэн зоч байсан?
- Д. Ишдорж: Цөөхөн байсан.
- Жужа: Зоч лам нар дугантай байсан уу?
- Д. Ишдорж: Байгаагүй, байгаа дуган нь тэр ганц гэр дуган.
- Жужа: Борчууд хар хүмүүс байсан уу?
- Д. Ишдорж: Энгийн улс тийм байгаагүй. / Тэр хавиар ойролцоо амьдардаг айлууд байсан уу гэж тодруулж асуув / Байдаг байсан. Уулын ар дээр амьдардаг.
- Жужа: Тэр жас хэзээ байгуулагдсан бэ?
- Д. Ишдорж: Мэдэхгүй, тэрнийг би ерөөсөө мэдэхгүй.
- Жужа: Хийдийг хэн байгуулж байсан бэ ?
- Д. Ишдорж: Мэдэхгүй.
- Жужа: Өөр хийдтэй холбоотой байсан уу?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. 2

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Д. Ишдорж: Байгаагүй, нэг лам ирдэг байсан юм даа. Тэр нь ямар учиртай хүн байсан юм. Багш нь гээд л нэг том лам ирдэг байсан юм. Арвайн хүрэнээс.

Жужа: Бясалгалын агуй гэж байсан уу?

Д. Ишдорж: Уулнаас буухлээр нэг агуй байсан. Нүхэнд нь тоглоод л тэгээд байдаг байсан.

Жужа: Жас бүтэн ганжуур байсан уу?

Д. Ишдорж: Ганжуур байсан. Ном л байдаг байсан. Чухам бүтэн байсан юм уу мэдэхгүй.

Жужа: Баянгийн жасын талаар яриарай?

Д. Ишдорж: Баянгийн жасыг сайн мэдэхгүй. 2, 3 дугантай тийм жас байсан.

Жужа: Тэр ямар дуган байсан бэ?

Д. Ишдорж: Дөрвөлжин модон дуган байсан.

Жужа: Хэд орчим лам байсан бол?

Д. Ишдорж: Мэдэхгүй.

Жужа: Уушигийн жасаас илүү юу, цөөхөн үү?

Д. Ишдорж: Мэдэхгүй, илүү л байсан байлгүй.

Жужа: Суварга байсан уу?

Д. Ишдорж: Мэдэхгүй, бага байсан болоод мэдэхгүй байна.

Жужа: Дэмчигийн сүмийн талаар?

Д. Ишдорж: Мэдэхгүй, Дэмчигийн сүм гэж сонсож байсан юм байна.

Жужа: Тахидаг овоо байсан уу?

Д. Ишдорж: Байсан, Уушигийн жасаас баруунтаа нэг жижигхэн улаан толгой бий. Тэрэн дээр овоотой, тэрийг л тахидаг.

Жужа: Та хэдэн он хүртэл тэнд сууж байсан бэ?

Д. Ишдорж: 1937 онд цэрэгт явсан, би. 1936 он хүртэл сууж байсан байх нь. Арван хэдтэй анх суусан шүү. 3, 4 жил суусан уу үгүй, юу тэгээд л хар болоод л.

Жужа: Хийдийг хэдэн онд хаагдсан бэ?

Д. Ишдорж: Намайг явчихсан хойгуур л, 1938 онд юм уу хаагдсан юм гэнэ лээ. Лам нар ч баригдсан. 1937 онд Арвайхээрт эцсийн майдар эргэх, эцсийн наадам хийх гээд л явж байсан юм. Майдартаа мөргөчихөөд л, наадмаа үзчихээд л явж байсан юм.

Жужа: Таниас гадна энэ Уушигийн жасын лам нар бий юу?

Д. Ишдорж: Энэ хойно Цэдэнгийн Дэмбэрэл гээд бий. Харин надаас илүү юм мэддэг, одоо байдаг л байгаа даа. Ноднин нэг бие нь муу, хэвтэрт орчихсон юм дуулдаад л байсан юм.

Жужа: Баянгийн жасд сууж байсан лам нар одоо энчээ байгаа юу?

Д. Ишдорж: Мэдэхгүй ээ. Тэр Баянгийн жасд сууж байсан хүн байдаг юм уу, үгүй юм уу мэдэхгүй.

Жужа: За баярлалаа.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. 3